



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан .....	4
2.1	Оршил .....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.8.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:.....	8
2.8.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн зарим аудитын дүнгийн талаар .....	8
2.8.3	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	11
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	13
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	13
2.11	Шилэн дансны мэдээлэл .....	14
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	14
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	15
3	Менежментийн захидал .....	16
3.1	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал .....	16
3.2	Дотоод хяналттай холбоотой асуудал .....	16
4	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	18
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	19
4.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	20
4.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	21
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	22
5	Хавсралт .....	24
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	24
5.2	Албан шаардлага .....	31

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ЗГТС	Засгийн газрын тусгай сан



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД С.ЧИНЗОРИГ  
ТАНАА

2019.04.25 № 851  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



## Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.БҮРЭНБАТ

## **2 Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төсвийн ерөнхийлөн захирагч С.Чинзориг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн авлагыг барагдуулах, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтыг сайжруулах зэрэг зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 4 дүгээр сарын 5-ны өдрөөс 2019 оны 4 дүгээр сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Энхдалай, гэрээт аудитор Б.Мөнгөнцэцэг нар гүйцэтгэв.

ХНХС 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 01/1026 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

## **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

ХНХЯ-ны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

ХНХЯ нь эрхэм зорилгоо “Хөдөлмөр, хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын харилцан хамаарал бүхий цогц бодлогыг хэрэгжүүлж, иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчин бий болгох, нийгмийн баталгааг дээшлүүлэх замаар хүний хөгжлийг хангахад оршино.” гэж тодорхойлсон байна.

ХНХЯ нь эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр дэвшүүлжээ. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, энэ чиглэлээр салбар хоорондын зохицуулалт хийх;
- Цалин хөлс, хөдөлмөрийн харилцааны оновчтой тогтолцоо, хөдөлмөрлөх таатай орчныг бүрдүүлэх;
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурласан мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөгжүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, ажиллах хүчний зохистой нөөцийг бий болгох, ажиллах хүчний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;
- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдийн амьдралын түвшнийг дээшлүүлэх;
- Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлж, хүн амын хөгжлийг хангах нийгмийн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн нийгмийн цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хүн амын насны бүтцийн хэтийн төлөвийг харгалзан хүн амын бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх замаар хүн амын нийгмийн хамгааллыг сайжруулах;
- Салбарын хүний нөөц, удирдлагын чадавх, зохион байгуулалтыг сайжруулах замаар үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг тасралтгүй дээшлүүлэх.

ХНХЯ-ны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 8 стратеги зорилтын хүрээнд 202 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан үүнээс 147 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 50 арга хэмжээг 50.0-89.0 хувь, 5 арга хэмжээг 10.0-49.0 хувийн биелэлттэй гэж үнэлсэн байна.

ХНХС-ын Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.



Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус яамны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

ХНХЯ санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн “Э-тайлан” програм хангамжийг ашигладаг байна.

ХНХЯ-ны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт сул гэж үзлээ.

Яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь салбарын бодлого, хууль, тогтоомжийн хэрэгжилт, сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хэрэгжүүлж ажилласан хэдий ч алдаа зөрчлийн тоо нэмэгдсэн.

ХНХЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас 2018 онд 17 байгууллага, төсөл арга хэмжээний үйл ажиллагаанд Дотоод аудитын хорооны тогтоолоор баталсан төлөвлөгөөт 8 аудит, цаг үеийн шаардлагатай уялдуулан төлөвлөгөөт бус 5 аудит, хяналт шалгалтыг хийсэн байна. Дотоод аудитаар нийт 880.0 сая төгрөгийн 84 зөрчлийг илрүүлж 57.5 сая төгрөгийн 8 зөрчилд акт тогтоож, 4.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 17 нэгжид 137 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн биелэлт 91.0 хувьтай байгаа бол акт, албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй алба, нэгжийн асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад ХНХЯ-ны бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 1,114,304.6 сая төгрөгийн 2 хувиар тооцон, материаллаг байдлын түвшнийг урьдчилсан байдлаар 22,286.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд 2018 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 1,237,826.9 сая төгрөгийн 2 хувиар тооцон, материаллаг байдлын түвшнийг 24,756.5 сая төгрөгөөр тогтоолоо.

Байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн нэгтгэсэн тайлан, балансын дансанд хийсэн эрсдэлийн үнэлгээг үндэслэн материаллаг байдлын түвшнийг суурь үзүүлэлтээс 2 хувиар тооцсон.

## 2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сайдын эрхлэх асуудлын хүрээний 185 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 146 байгууллага, нэгжийн санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргасан. Мөн 29 нэгжийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан бол 5 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 5 нэгжийн санхүүгийн тайлан аудитад хамрагдаагүй байна.

Хүснэгт 1 (Санхүүгийн тайлан аудитад хамрагдсан байдал, тоогоор)

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэгдсэн	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагчид	50	5		1	5
2	Төрийн өмчит аж ахуйн нэгж	1				
3	Засгийн газрын тусгай сан	3				
4	Халамжийн сангийн харьяа дэд сангууд	29	1		1	
5	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн харьяа дэд сангууд	32	1			
6	Төсвийн төвлөрүүлэн захирагч	1				
7	ХХҮЕГ-ын харьяа байгууллагууд	30			3	
8	Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагууд			22		
	<b>Нийт</b>	<b>146</b>	<b>2</b>	<b>22</b>	<b>5</b>	<b>5</b>

Эх сурвалж: Аудит хийсэн тайлан



Аудитаар 124 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 21 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 1 санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгсөн.

### 2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 17,199.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 17.6 хувь буюу 3,032.4 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 0.6 хувь буюу 95.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 28.3 хувь буюу 4,876.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 53.5 хувь буюу 9,195.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлсэн байна.

ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нийт 3,032.4 сая төгрөгийн алдааг залруулсныг задлан үзвэл, Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 284.0 сая, Засгийн газрын тусгай сангийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 1,010.0 сая, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд 1,063.6 сая төгрөг тус тус байна.

ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 2 (Алдаа, зөрчлийн нэгтгэл түүний шийдвэрлэлт, сая төгрөгөөр)

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
				Зөвлөмж		Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцуулах санал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ	171	3,093.2	83	1,531.8	44	59.2	44	1,502.2		
2	ТӨҮГ	10	60.1	7	58.6	1	1.5	2	-		
3	ЗГТС	79	8,891.8	46	7,432.3	9	28.0	12	1,431.5	12	
4	ТТЗ	57	491.9	31	172.6	9	7.0	14	312.3	3	
5	ТЕЗ	9	1,630.0					2	1,630.0	7	
	<b>Дүн</b>	<b>326</b>	<b>14,167.0</b>	<b>167</b>	<b>9,195.3</b>	<b>63</b>	<b>95.7</b>	<b>74</b>	<b>4,876.0</b>	<b>22</b>	<b>-</b>

Эх сурвалж: Аудит хийсэн тайлан

### 2.8.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн зарим аудитын дүнгийн талаар

#### Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 33 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн. Харьяа газруудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 26 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 3 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгч, 1 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 3 санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

Харьяа байгууллагуудын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 491.9 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрсэн. Тухайлбал:

1. Тайлант хугацаанд гадаад болон дотоод албан томилолтод нийт 95.6 сая төгрөг зарцуулснаас 10.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.
2. Өмнөх оны давсан орлогоос авлагаар тооцож төвлөрүүлсэн 80.3 сая төгрөгийг өөрийн хөрөнгө оруулалтад зарцуулалгүй 64.0 сая төгрөгийн үнэ бүхий Ниссан тийна маркын автомашин худалдан авч ХНХЯ-нд шилжүүлсэн байна.

#### Нийгмийн халамжийн сан

Нийгмийн халамжийн сангийн сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 30 дэд сангийн тайланг нэгтгэгдсэн. Дэд сангуудын тайланд хийсэн аудитаар 28 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 1 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгч, 1 санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн.

Нийгмийн халамжийн сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 3,293.4 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил илрүүлсэн. Тухайлбал:

1. Улсын мэдээллийн маягт хэвлүүлэх зардлаас 14.5 сая төгрөгөөр Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, 9.9 сая төгрөгөөр хуулийн эмхэтгэл, ном хэвлүүлсэн.
2. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 3,131.3 сая төгрөгийн өр төлбөр тайлагнаснаас 80.0 хувь буюу 2,496.9 сая төгрөг нь цалинтай ээж хөтөлбөрийн санхүүжилтийг хугацаанд нь олгоогүйтэй холбоотойгоор өр төлбөр нэмэгдсэн байна.

#### Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 32 дэд сангийн тайланг нэгтгэсэн. Дэд сангуудын тайланд хийсэн аудитаар 21 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 10 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 1 санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгсөн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 5,594.5 сая төгрөгийн зөрчил илрүүлсэн. Тухайлбал:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн харьяа дэд сангуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар Говь-Алтай, Хөвсгөл аймаг, Багахангай, Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар, Налайх, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг, Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, Баянзүрх дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгсөн.
2. Хөтөлбөр, үйл ажиллагаанд зарцуулсан 150.3 сая төгрөгийн хөрөнгө, зардлыг буруу ангилан бүртгэсэн, 120.2 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй, 28.5 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлээгүй.

3. Орон нутаг, нийслэлийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийг Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөр хэлэлцүүлээгүй, тэргүүлэх чиглэл, шалгуур үзүүлэлтийг хангаагүй төсөл хөтөлбөрт 2,115.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон, 33.0 сая төгрөгийн төслийг хэрэгжүүлээгүй, зориулалтын дагуу зарцуулаагүй, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олгосон 671.2 сая төгрөгийн зээл, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг хугацаанд нь төвлөрүүлээгүй.
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2018 оны 12 дугаар сарын 21-ын өдөр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга нар хамтарсан А/283, А/25 дугаартай тушаалаар 2018 оны 12 дугаар сарын 24-өөс 2019 оны 6 дугаар сарын 25-ны өдөр хүртэл Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангах 25 төрийн бус байгууллагад санхүүгийн дэмжлэг олгох гэрээг байгуулан 249.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгон, урьдчилж гарсан зардлаар бүртгэж өр төлбөрийг нэмэгдүүлсэн.
5. Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн санхүүжилтээр 29 аж ахуйн нэгж, иргэнд 2017 онд олгосон 3,986.0 сая санхүүгийн дэмжлэгээс гэрээний дагуу 336.1 сая төгрөгийг буцаан төвлөрүүлэхээс 10 аж ахуйн нэгж, иргэн дутуу, 8 нь огт төлөлт хийгээгүй нийт 19.5 сая төгрөгийг буцааж төвлөрүүлээгүй, 5 төслийн хэрэгжилтийн явцын талаар тайлан, мэдээ ирүүлээгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд илэрсэн дээрх залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшнээс их байгааг харгалзан “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн.

#### Төсвийн шууд захирагчид

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 61 төсөвт байгууллага, төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 50 санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргасан, 5 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж 1 санхүүгийн тайланд итгэл үзүүлэн, 5 санхүүгийн тайлан аудитад хамрагдаагүй байна.

Аудитаар 44 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 6 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн.

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд 3,093.2 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрсэн. Тухайлбал:

1. Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төсөл 972.8 сая, Хөдөлмөр эрхлэх ур чадварыг сайжруулах төсөл 20.3 сая төгрөгөөр тус тус батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан;
2. ХНХЯ-ны харьяа байгууллагууд төсвийн хөрөнгөөс 382.6 сая төгрөгийг удирдах ажилтны зөвлөгөөн, системийн спортын арга хэмжээ, ахмадын өдөр зохион байгуулах, байгууллагын брендбүүк хийлгэсэн, хөрөнгө бэлтгэсэн, магистр, докторын сургалтын төлбөр, ойн арга хэмжээ, түлээ нүүрсний хөнгөлөлт, шагнал, шүүхийн шийдвэрийн нөхөн олговорт цалин, сургалт,

хүүхэд хамгааллын зардлаас тус тус зориулалт зөрчин, кино, жүжиг хийлгэх, хүүхдүүдэд үзүүлэхэд зориулан үрэлгэн зарцуулсан;

3. “Салбарын болон байгууллагын үйл ажиллагаанд судалгаа шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх” 50.0 сая төгрөгийн ажлын гэрээ байгуулж, урьдчилгаа төлбөрт 40.0 сая төгрөг төлсөн боловч ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй, хүлээн аваагүй, гэрээг сунгаагүй, хариуцлагын талаар зүйл, заалт гэрээнд оруулаагүй;
4. Дотуур байрны түрээсийн орлогыг төвлөрүүлээгүй зарцуулсан 37.0 сая, орлогыг харилцах дансанд төвлөрүүлээгүй кассаас зарцуулсан 121.1 сая, хөрөнгийн тооллого хийгээгүй 59.9 сая, газрыг үнэлээгүй, хөрөнгийг бүртгээгүй, буруу ангилан бүртгэсэн 50.2 сая, хөрөнгийг шууд зардлаар бүртгэсэн, тооцооны дансаар дамжуулаагүй 46.3 сая, шатахууны зарцуулалтын тайлангүй 17.6 сая, цалинг илүү тооцож олгосон, урьдчилгааг суутгаагүй, хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцоогүй 11.0 сая, анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн 33.7 сая, авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй 190.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

#### Төрийн өмчит үйлдвэрийн газар

Олон улсын хүүхдийн “Найрамдал” цогцолборын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 60.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн үүнээс 1.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2 зөрчлийг арилгах албан шаардлага, 58.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүллээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд илэрсэн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, хууль, журмын хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчлүүдэд нийт 167 зөвлөмж өгсөн. Төсвийн захирагч нар зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Ахмад настны үндэсний төв, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Булган, Орхон дахь аймаг МСҮТ, Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төслийн нэгж, Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төслийн нэгжүүд, Засгийн газрын тусгай сангуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар “Хязгаарлалттай” дүгнэлт авсан Налайх дүүргийн нийгмийн халамжийн сан, Говь-Алтай, Хөвсгөл аймаг, Нийслэл, Баянгол, Багахангай, Налайх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, “Сөрөг” санал дүгнэлт авсан Баянзүрх дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн захирагч нарт хариуцлага тооцуулах албан шаардлагыг холбогдох дээд шатны төсөв захирагч нарт хүргүүлж байна.

#### **2.8.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд тусгаж, бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

### **Асуудал 1: Санхүүгийн тайлангийн залруулга**

Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд харьяа байгууллагуудын тайлангийн дахин үнэлгээг бүртгээгүй 52.8 сая, үндсэн хөрөнгийн элэгдлийг буруу дүнгээр тусгасан 343.5 сая, төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг оруулсан, буруу тайлагнасан 245.4 сая нийт 655.1 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүд болон Сангийн сайдын 2006 оны 388 тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

**Шийдэл:** Алдааг санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд 655.1 сая төгрөгийн залруулга хийлгэсэн;

### **Асуудал 2: Балансын данстай холбоотой асуудал**

Өнөр бүл хүүхдийн төвийн санхүүгийн тайланд бүртгэлтэй 6,456.0 мянган төгрөгийн өртөгтэй клубийн барилга, 19,368.3 мянган төгрөгийн өртөгтэй агуулахын барилга, 15,497.6 мянган төгрөгийн өртөгтэй талхны цехийн барилгыг буулгасан боловч данс бүртгэлээс хасаагүй, 175.0 мянган төгрөгийн өртөгтэй худгийн байр, газар болон өмчлөлийн хувьд маргаантай 17,500.0 мянган төгрөгийн өртөгтэй ажилчдын байр, 5,145.0 мянган төгрөгийн өртөгтэй ногооны зоорь зэрэг барилга, байгууламжуудад дахин үнэлгээ хийгдээгүй, Ховдын хөгжил политехник коллежийн санхүүгийн тайланд бүртгэлтэй 8 айлын орон сууцны барилгын газар болон үйлдвэрлэлийн дадлагын талбайг үнэлж бүртгээгүй байна.

**Шийдэл:** Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн;

### **Асуудал 3: Авлагын данстай холбоотой асуудал**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээлийг санхүүжүүлэхээр Капитал банканд 2016 онд олгосон дамжуулан зээлийн үлдэгдлээс 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 6,650.0 сая төгрөг барагдаагүй, 265.6 сая төгрөгийн зээлийн алдангийн үлдэгдэл бүртгэлтэй байсан. Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газраас хийсэн “2018 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилт явц”-д хийсэн аудитаар 7,000.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосноор 2019 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар жижиг зээлийн үлдэгдлээс 5,350.0 сая төгрөгийг барагдуулж 1,300.0 сая төгрөг үлдэгдэлтэй байна. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн А-96 дугаар тушаалаар Капитал банкныг албадан татан буулгах шийдвэр гарсан байна. 2019 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар

дамжуулан зээлийн үлдэгдэл 1,300.0 сая, зээлийн алдангийн үлдэгдэл 265.6 сая нийт 1,565.6 сая төгрөгийн авлага барагдаагүй байна.

**Шийдэл:** Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн;

## **2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээр дамжуулан хэрэгжиж байгаа Нэг өрх–нэг ажлын байр хөтөлбөрийн хүрээнд 2017-2018 онд нийт 63 иргэнд 151.0 сая төгрөгийн зээл олгосноос 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 109.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланд 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 22,469.9 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн үлдэгдэл бүртгэлтэй байна. Тухайлбал:

- Оёдлын нэгдсэн холбоонд “Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд 2013 онд дамжуулан зээлдүүлэх гэрээгээр олгосон зээлээс 15,819.9 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн үлдэгдэл барагдаагүй зээлийн барагдуулахаар тухайн үед зээлийг хариуцаж олгосон Хүнс, хөдөө аж, ахуйн яам шүүхэд нэхэмжлэл гаргасан байна.

## **2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 13 хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан 1,267,659.9 сая төгрөгийн зардлын төсөв батлагдсанаас 1,175,526.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 631.1 сая төгрөгийг нийгмийн даатгалын төсвөөс, 70,989.1 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас, 9,513.7 сая төгрөгийг тусламжийн, 11,000.0 сая төгрөгийг бусад эх үүсвэрээс санхүүжүүлэхээр тус тус батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн орлогыг авч үзвэл улсын төсвөөс 1,174,956.2 сая, эрүүл мэндийн даатгалын сангаас 496.6 сая, урьд оны үлдэгдлээс 39,244.0 сая, гадаад эх үүсвэрээс 16,752.3 сая, тусламжийн эх үүсвэрээс 96.0 сая төгрөгийн санхүүжилт авсан бол үндсэн үйл ажиллагаанаас 53,371.7 сая, туслах үйл ажиллагаанаас 3,514.7 сая, төсөв болон дамжуулан олгосон зээлээс эргэн төлөгдөх эх үүсвэрээс 4,350.0 сая төгрөгийн орлого, нийт 1,292,781.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж 1,222,717.0 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, 65,742.0 сая төгрөгийг төсвийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн, санхүүгийн нэгтгэсэн тайлангаарх мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,283.4 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 9,605.9 сая төгрөг байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зардал нийт 1,222,717.0 сая төгрөг буюу 96.5 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил,



нийгмийн даатгалын шимтгэл 771.8 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,366.1 сая, хангамж бараа материал бэлтгэх зардалд 68.0 сая, нормативт зардал 756.0 сая, эд хогшил урсгал засварын зардал 20.4 сая, томилолт зочны зардалд 51.0 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 1,678.6 сая, бараа үйлчилгээний бусад зардал 845.3 сая, урсгал шилжүүлгийг 21,005.7 сая, хөрөнгийн зардлыг 11,380.2 сая, эргэн төлөгдөх зээлд 7,000.0 төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хандив тусламжийн орлогоос 2,919.1 сая, олон улсын байгууллагаас авсан хөнгөлөлттэй зээл 315.2 сая, Засаг даргын нөөц сан болон бусад шатны төсөв захирагчаас авсан хөрөнгө 889.9 сая, дээд шатны төсөв захирагчаас хуваарилсан хөрөнгө 922.9 сая, төсвийн байгууллагын үйл ажиллагаанаас бий болсон нэмэлт орлого 584.7 сая төгрөг, нийт 5,631.8 сая төгрөг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 5,499.4 сая, хөрөнгийн зардалд 132.4 сая төгрөгийг зарцуулж улсын төсөвт 471.9 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

## **2.11 Шилэн дансны мэдээлэл**

ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр зэрэг 23 мэдээллийг хэрхэн байршуулсан талаар ХНХЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас гаргасан 2018 оны жилийн эцсийн тайлангаас үзэхэд 3 байгууллага тус бүр 1 мэдээллийг байршуулаагүй, 1-13 байгууллага мэдээллийг шилэн дансны нэгдсэн мэдээллийн цахим хуудсанд хоцроож байршуулсан, 23 мэдээллийг байршуулсан байдал 74.5-100.0 хувь буюу дунджаар 87.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

ХНХЯ-ны Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 188 зөвлөмж өгснөөс 156 зөвлөмжийг хэрэгжүүлж, 29 нь хэрэгжих шатанд, 3 хэрэгжээгүй нийт 86.6 хувийн биелэлттэй байна. Тухайлбал:

### **Хэрэгжээгүй зөвлөмж**

- **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан-** Тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй татан буугдсан Анод банк болон Дэлгэр экспресс ББСБ–аас авах 847.5 сая төгрөг авлага эргэн төлөгдөх найдваргүй байна. Дэлгэр экспресс ББСБ–аас авах авлагын талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт хандаж тодруулсан.
- **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв-** Агаар сувилал ажиллаагүйгээс туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө биелээгүй байна. 2018 оны туслах үйл ажиллагааны орлого бүрдүүлэх Агаар сувиллаа ажиллуулах боломж байхгүй тул туслах үйл ажиллагааны орлогыг үндсэн үйл ажиллагааны

орлого руу шилжүүлэх хүсэлт харьяа яаманд хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй.

- **Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар-** Санхүүгийн тайланд 209.8 сая төгрөгийн авлага тайлагнаснаас 2010 онд үүссэн Сангийн яамнаас авах 7.6 сая төгрөгийн авлагыг шийдвэрлээгүй.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримтаар баталгаажуулж, гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээнд төрөөс хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, хөтөлбөрийн суурь судалгаа шинжилгээ, хэтийн болон ойрын тооцоолол хийж, зөвлөмж боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлдэг “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт” ажилладаг боловч яам болон харьяа байгууллагууд төрийн бус байгууллага, хувь хүмүүстэй гэрээ байгуулан судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгүүлж байгаа нь төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах ажил хангалтгүй байгаад анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

Эрсдэл: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх, төсвийг үр ашиггүй зарцуулах, гэрээт ажлын чанар хангалтгүй байх;

Өгсөн зөвлөмж: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулж байх, харьяа байгууллагаар судалгаа хийлгүүлэх ажлыг зохион байгуулах;

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана;

#### 3.2 Дотоод хяналттай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Харьяа байгууллагуудад батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан, эд хөрөнгийн тооллого хийгээгүй, чанаргүй гүйцэтгэсэн, тооцоо бодоогүй, хөрөнгө дутагдсан,

хөрөнгө бодитоор оршин байхгүй, өмчлөлийн маргаантай, газрыг үнэлж бүртгээгүй, анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж бүртгэлд тусгасан, төсвийг зориулалт бус, үрэлгэн зарцуулдаг зэрэг зөрчил, дутагдал гарч байна. Мөн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн судалгаанаас үзэхэд шилэн дансны мэдээллийн цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулаагүй, хугацаа хоцроосон зэргээс хэрэгжилт 87.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, 7 байгууллага, 11 дэд сан, 2 төсөл хөтөлбөрийн нэгжийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, Баянзүрх дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгсөн.

Эрсдэл: Дотоод хяналтыг үр нөлөөгүй хэрэгжүүлснээс санхүүгийн үйл ажиллагаанд зөрчил, дутагдал гарах, холбогдох хууль, тогтоолын хэрэгжилт хангагдахгүй байх;

Өгсөн зөвлөмж: Салбар нэгжүүдийн санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах, өгсөн зөвлөмж, тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагыг хэрэгжүүлэх;

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

##### 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	2017 оны 12 дугаар сарын 31	2018 оны 12 дугаар сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>140,336,941.1</u></b>	<b><u>189,369,477.6</u></b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,283,386.4	9,605,928.2
33	АВЛАГА	112,997,036.0	146,714,239.9
34	УРЬДЧИЛГАА	603,870.4	343,734.5
35	БАРАА МАТЕРИАЛ	13,612,445.2	14,829,825.0
36	НӨӨЦИЙН БАРАА	7,840,203.2	17,875,750.1
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>194,801,236.0</u></b>	<b><u>303,520,911.1</u></b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	194,801,236.0	303,520,911.1
392	Биет хөрөнгө	193,948,032.8	268,774,315.8
393	Биет бус хөрөнгө	853,203.2	34,746,595.3
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>335,138,177.1</u></b>	<b><u>492,890,388.8</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>7,331,330.7</u></b>	<b><u>31,236,350.0</u></b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,738,225.7	23,183,306.0
412	Богино хугацаат зээлийн өглөг	33,795.9	10,250.9
413	Өглөг	1,611,149.4	4,390,447.3
414	Урьдчилж орсон орлого	93,280.4	18,782,607.8
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,593,105.0	8,053,044.0
422	Урт хугацаат зээл	5,593,105.0	8,053,044.0
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>327,806,846.4</u></b>	<b><u>461,654,038.8</u></b>
51	Засгийн газрын хувь оролцоо	327,806,846.4	461,654,038.8
